



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 244

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар дахин худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны “Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй нийт 59,331,313.00 (тавин есөн сая гурван зуун гучин нэгэн мянга гурван зуун арван гурван) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины 3 дахь нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал, Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Т.Энхбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль, захиргааны актын дагуу зохион байгуулах,

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 А.АРИУНБОЛД

0000121

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн
24 дүгээр тогтоолын хавсралт

Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
нээлттэй дуудлагын худалдаагаар дахин худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	ТӨБЗГ-ын 2017 оны 297 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)
1	Ланд круйзер-80, 99-89 СҮА, суудлын, ADJ81-0028987	1992/2008	23,000,000.00	23,000,000.00	-	4,000,000.00	2,000,000.00	500,000.00
2	ЗИЛ-130 ТСВ-6, ГАМ-046, тусгай, 798469, 542866	1970/1972	2,370,000.00	2,370,000.00	-	5,000,000.00	2,500,000.00	625,000.00
3	ЗИЛ-130 АЦ-40, ГАМ-00, тусгай, 15426378	1986/2000	7,000,000.00	7,000,000.00	-	5,000,000.00	2,500,000.00	625,000.00
4	ГАЗ-3307, тусгай, 94079, 1608349	1986/1991	7,030,000.00	7,030,000.00	-	4,000,000.00	2,000,000.00	500,000.00
5	УАЗ-31512, суудлын, 60011505, 70560790	2006/2006	14,060,000.00	14,060,000.00	-	2,500,000.00	1,250,000.00	312,500.00
6	ГАЗ-66, тусгай, 1346875, 0078202	1986/1986	2,721,313.00	2,721,313.00	-	4,000,000.00	2,000,000.00	500,000.00
7	УАЗ-31512, суудлын, 10802265, 10022435	2001/2001	3,150,000.00	3,150,000.00	-	2,500,000.00	1,250,000.00	312,500.00
НИЙТ ДҮН			59,331,313.00 (тавин есөн сая гурван зуун гучин нэгэн мянга гурван зуун арван гурван төгрөг)	59,331,313.00 (тавин есөн сая гурван зуун гучин нэгэн мянга гурван зуун арван гурван төгрөг)	-	27,000,000.00 (хорин долоон сая төгрөг)	13,500,000.00 (арван гурван сая таван зуун мянган төгрөг)	3,375,000.00 (гурван сая гурван зуун далан таван мянган төгрөг)